

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3.	Менежментийн захидал.....	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаал

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГААЛЬ, ТАТВАР, САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Т.БАТБИЛЭГ
ТАНАА

2019.02.25 № 06/331
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус хүрээлэнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн захирал Т.Батбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 22-ноос 2019 оны 2 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 01/86 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь санхүүгийн салбарт мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, цахим засаглалыг бэхжүүлэхэд манлайлагч хамт олон байна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагаа нь гааль, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах, техник технологийн хэвийн үйл ажиллагааг хариуцах чиглэлийн дагуу явагддаг байна.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засгийн Газрын 2016 оны 177 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" улсын үйлдвэрийн газрын дүрэм

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус төвийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Имиралд" програм хангамж ашигладаг байна.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "бага" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тус байгууллага нь улсын төсвөөс санхүүждэг, төрийн бодлогоор тодорхой зорилт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон төлбөрийн системийг боловсронгуй болгох зорилгоор төсвийн санхүүжилтийг зарцуулдагтай холбоотой.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны нийт зардал нь 2,310,390.7 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 46,207.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	6,616.0	
	Дүн	2	6,616.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад бараа ажил үйлчилгээний үнийг хувь хүний дансанд шилжүүлсэн эсэх, холбогдох татвар шимтгэлийг тооцож тайлагнасан эсэхийг түүвэр шалгалтаар гүйцэтгэж, баталгаажуулсан тул бүрэн шалгаж, тулган баталгаажуулж амжаагүй болно. Мөн арилжааны банкин дахь дансыг шалгах.

2.10. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 2,272,550.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,272,407.7 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Нийт төсвийг 0.1 хувь буюу 125.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.13. САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь 2018 оны 3 дугаар сарын 21-нд хувь хүнд сурталчилгааны тайз материалын зардлын үнэ болох 2,566.0 мянган төгрөгийг хувийн дансанд нь шилжүүлэхдээ хувь хүний орлогын албан татварыг суутган аваагүй байна.

1.2 Батламж мэдэгдэл:

Энэ нь “тохиолдсон байх ба эрх үүрэг, үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан тухай хуулийн 12.1.2-т “хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлогод тухайн хуулийн 26.1.3-т заасны дагуу албан татварыг тухай бүр ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.3 Эрсдэл:

Холбогдох хууль, дүрэм, журам, зааврын заалт хэрэгжихгүй байх

1.4 Өгсөн зөвлөмж:

Цаашид холбогдох хууль, дүрэм, заавар, журмыг мөрдөж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ҮАГ-т албан бичгээр ирүүлэх.

1.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, цаашид хууль дүрмийг мөрдөж ажиллана.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн байгууллага нь 2018 онд нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын сугалааны тохирлын хяналтын 9 гишүүдийн ажлын хөлс болох 4,050.0 мянган төгрөгийг өөрийн ажилтны хувийн дансаар дамжуулан олгохдоо Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12.1.2-т “хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлогод тухайн хуулийн 26.1.3-т заасны дагуу албан татварыг тухай бүр ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Батламж мэдэгдэл:

Энэ нь “тохиолдсон байх ба эрх үүрэг, үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан тухай хуулийн 12.1.2-т “хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлогод тухайн хуулийн 26.1.3-т заасны дагуу албан татварыг тухай бүр ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.3 Эрсдэл:

Холбогдох хууль, дүрэм, журам, зааврын заалт хэрэгжихгүй байх, албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах.

2.4 Өгсөн зөвлөмж:

Цаашид холбогдох хууль, дүрэм, заавар, журмыг мөрдөж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

2.5 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Тус зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, цаашид хууль дүрмийг мөрдөж ажиллана.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,099,617.00	3,284,897.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,632.00	31,314.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,632.00	31,314.50
3121	Төгрөг	13,632.00	31,314.50
31211	Төрийн сангийн харилцах	13,632.00	
31213	Арилжааны банк дахь харилцах		31,314.50
35	БАРАА МАТЕРИАЛ	3,085,985.00	3,253,583.00
354	Хангамжийн материал	3,085,985.00	3,253,583.00
35410	Бичиг хэргийн материал	298,000.00	298,000.00
35420	Аж ахуйн материал		167,598.00
35470	Бусад хангамжийн материал	2,787,985.00	2,787,985.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	393,132,552.32	346,193,575.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	393,132,552.32	346,193,575.92
392	Биет хөрөнгө	385,200,244.08	342,239,891.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	326,208,336.07	274,953,648.74
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,725,098.43	61,327,247.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,266,809.58	5,958,995.41
393	Биет бус хөрөнгө	7,932,308.24	3,953,684.14
39301	Програм хангамж	7,188,226.99	3,522,134.14
39303	Бусад биет бус хөрөнгө	744,081.25	431,550.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	396,232,169.32	349,478,473.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,128,448.38	214,984.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,128,448.38	214,984.29
413	Өглөг	9,128,448.38	214,984.29
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,893,248.38	
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	4,235,200.00	
4136	Бусад өглөг	-	214,984.29
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		214,984.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	387,103,720.94	349,263,489.13
51	Засгийн газрын хувь оролцоо	387,103,720.94	349,263,489.13
512	Хуримтлагдсан үр дүн	387,103,720.94	349,263,489.13
51210	Өмнөх үеийн үр дүн	403,446,422.78	387,103,720.94
51220	Тайлант үеийн үр дүн	-16,342,701.84	-37,840,231.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	396,232,169.32	349,478,473.42

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,486,907,030.56	2,272,550,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,615,430.56	-
120	Нийтлэг татварын бус орлого	51,615,430.56	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,968,419.56	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,968,419.56	-
120009	Бусад орлого	1,647,011.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,435,291,600.00	2,272,550,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1330	Төсвийн захирагчдаас	1,435,291,600.00	2,272,550,500.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,435,291,600.00	2,272,550,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,503,249,732.40	2,310,390,731.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,503,249,732.40	2,310,390,731.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,490,206,748.00	2,310,265,661.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,013,032,990.38	887,648,417.64
210101	Үндсэн цалин	921,706,895.54	773,964,101.32
210102	Нэмэгдэл		84,763,216.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,491,640.39	28,921,100.00
210104	Урамшуулал	13,020,400.00	
210105	Гэрээт ажлын хөлс	47,814,054.45	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,638,800.00	126,285,430.92
210201	Тэтгэврийн даатгал	122,638,800.00	126,285,430.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,364,547.20	87,324,753.47
210301	Гэрэл, цахилгаан	5,131,763.23	13,970,912.01
210302	Түлш, халаалт	2,768,069.49	1,217,851.17
210303	Цэвэр, бохир ус	2,267,854.00	682,872.02
210304	Байрны түрээс	70,196,860.48	71,453,118.27
2104	Хангамж, бараа материалын зардал	12,006,236.56	10,936,035.51
210401	Бичиг хэрэг	3,892,978.00	3,137,570.00
210402	Тээвэр, шатахуун	3,408,320.00	2,903,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	289,798.56	119,465.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,415,140.00	4,776,000.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	399,000.00	1,556,002.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	399,000.00	1,556,002.00
2107	Томилолт, зочны зардал	16,639,607.00	18,335,600.00
210702	Дотоод албан томилолт	5,525,800.00	16,310,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	11,113,807.00	2,025,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,665,628.84	984,011,162.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,381,928.84	974,014,662.18

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,783,700.00	7,496,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,459,938.02	194,168,260.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		44,228,734.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	121,459,938.02	149,939,526.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,042,984.40	125,070.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,020,200.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,020,200.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,784.40	125,070.09
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,784.40	125,070.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-16,342,701.84</u>	<u>-37,840,231.81</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-16,342,701.84</u>	<u>-37,840,231.81</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,436,938,611.00</u>	<u>2,272,550,500.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,647,011.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,647,011.00	-
120009	Бусад орлого	1,647,011.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,435,291,600.00	2,272,550,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,435,291,600.00	2,272,550,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,435,291,600.00	2,272,550,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,436,929,531.00</u>	<u>2,272,532,817.50</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,436,929,531.00	2,272,532,817.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,423,886,546.60	2,272,407,747.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,013,032,990.38	887,648,417.64
210101	Үндсэн цалин	971,649,388.93	671,453,006.01
210102	Нэмэгдэл		154,058,458.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,047,388.00	28,968,131.23
210104	Урамшуулал	4,634,117.00	33,168,821.80
210105	Гэрээт ажлын хөлс	17,702,096.45	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,638,800.00	106,519,900.00
210201	Тэтгэврийн даатгал	122,638,800.00	68,054,200.00
210202	Тэтгэмжийн даатгал		5,916,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		13,169,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал		147,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал		19,231,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,471,298.82	75,736,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,766,079.71	5,949,254.16
210302	Түлш, халаалт	2,436,796.11	1,549,124.55
210303	Цэвэр, бохир ус	2,092,423.00	858,303.02
210304	Байрны түрээс	66,176,000.00	67,380,118.27
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	18,330,771.56	11,341,199.91
210401	Бичиг хэрэг	3,742,078.00	3,426,570.00
210402	Тээвэр, шатахуун	3,186,000.00	2,903,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	146,798.56	57,220.41
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,255,895.00	4,954,409.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,650,000.00	2,650,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,650,000.00	2,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	17,793,557.00	17,810,000.00
210702	Дотоод албан томилолт	5,758,120.00	16,310,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	12,035,437.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	143,969,128.84	1,070,701,429.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,822,128.84	1,048,201,429.86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,647,000.00	20,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	100,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		100,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,042,984.40	125,070.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,020,200.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,020,200.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,784.40	125,070.09
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,784.40	125,070.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,080.00</u>	<u>17,682.50</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,080.00	17,682.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,552.00	13,632.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,632.00	31,314.50

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		403,446,422.78	403,446,422.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		403,446,422.78	403,446,422.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
Тайлант үеийн үр дүн		-16,342,701.84	-16,342,701.84
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		387,103,720.94	387,103,720.94
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		370,761,019.10	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		387,103,720.94	387,103,720.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			-
Тайлант үеийн үр дүн		-37,840,231.81	-37,840,231.81
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		349,263,489.13	349,263,489.13

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		13,632.00	-13,632.00	100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,272,550,500.00	2,272,407,747.41	142,752.59	99.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,272,550,500.00	2,272,407,747.41	142,752.59	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,272,550,500.00	2,272,407,747.41	142,752.59	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	887,666,100.00	887,648,417.64	17,682.36	100.00
210101	Үндсэн цалин	677,896,600.00	671,453,006.01	6,443,593.99	99.05
210102	Нэмэгдэл	150,464,800.00	154,058,458.60	-3,593,658.60	102.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,264,000.00	28,968,131.23	4,295,868.77	87.09
210104	Урамшуулал	26,040,700.00	33,168,821.80	-7,128,121.80	127.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,519,900.00	106,519,900.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	71,013,300.00	68,054,200.00	2,959,100.00	95.83
210202	Тэтгэмжийн даатгал	8,876,700.00	5,916,700.00	2,960,000.00	66.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,101,300.00	13,169,300.00	-6,068,000.00	185.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,775,300.00	147,900.00	1,627,400.00	8.33
210205	Эрүүл мэндийн даатгал	17,753,300.00	19,231,800.00	-1,478,500.00	108.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,736,800.00	75,736,800.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,738,800.00	5,949,254.16	-1,210,454.16	125.54
210302	Түлш, халаалт	2,079,000.00	1,549,124.55	529,875.45	74.51
210303	Цэвэр, бохир ус	1,287,000.00	858,303.02	428,696.98	66.69
210304	Байрны түрээс	67,632,000.00	67,380,118.27	251,881.73	99.63
2104	Хангамж, бараа материалын зардал	11,341,200.00	11,341,199.91	-	100.00
210401	Бичиг хэрэг	6,058,800.00	3,426,570.00	2,632,230.00	56.56
210402	Тээвэр, шатахуун	3,534,300.00	2,903,000.00	631,300.00	82.14
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	545,300.00	57,220.41	488,079.59	10.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,202,800.00	4,954,409.50	-3,751,609.50	411.91
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,650,000.00	2,650,000.00	-	100.00

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,650,000.00	2,650,000.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	17,810,000.00	17,810,000.00	-	100.00
210701	Гадаад албан томилолт			-	
210702	Дотоод албан томилолт	16,310,000.00	16,310,000.00	-	100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,070,826,500.00	1,070,701,429.86	125,070.14	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,048,326,500.00	1,048,201,429.86	125,070.14	99.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,000,000.00	20,000,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000,000.00	100,000,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000,000.00	100,000,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,272,550,500.00	2,272,425,429.91	125,070.09	99.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,272,550,500.00	2,272,425,429.91	125,070.09	99.99
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,272,550,500.00	2,272,425,429.91	125,070.09	99.99
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,632.00	13,632.00	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,314.50	31,314.50	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58.00	58.00	-	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	-	-
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	-
620004	Гэрээт ажилтан	17.00	17.00	-	-

Хавсралт

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр:	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/80/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Гэрээт ажилтан болон нэг удаагийн шинжтэй ажлын хөлснөөс хувь хүний орлогын албан татварыг суутган аваагүй байх, тайланд тусгаагүй байна.	2,566.00	Зөвлөмж өгч, зөрчлийг 2019 онд залруулах	Нягтлан бодогч	Г. Загдсүрэн
2	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын сугалааны тохирлын хяналтын гишүүдийн ажлын хөлсийг өөрийн ажилтнаар дамжуулан олгосон.	4,050.00	Зөвлөмж өгч, зөрчлийг 2019 онд залруулах	Нягтлан бодогч	Г. Загдсүрэн
	Нийт дүн	6,616.00			